

### **III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Энэхүү аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны 2024 оны жилийн эцсийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого заавар, тайлбар, тодруулгыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, холбогдох хууль, журмын хүрээнд үнэн зөв гаргасан эсэх талаар аудитын дүгнэлт, санал зөвлөмж гаргана.

#### **Ажлын хамрах хүрээ:**

1. “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдлын тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тайлбар, тодруулгыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв гаргасан эсэх талаар аудитын дүгнэлт гаргах, санал, зөвлөмж өгөх;
2. Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон шинээр мөрдөж эхлэх стандартын өөрчлөлт, нөлөөллийн талаар санал, зөвлөмж өгөх;
3. Санхүүгийн тайлагналтай холбоотой дотоод хяналтыг үнэлэх, хяналтын эрсдэлийг тодорхойлж үнэлэх, материаллаг сул тал оршин байгаа эсэхийг тодорхойлох;
4. “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагад аудитын ажлын үр дүнгийн талаар танилцуулга хийх.
5. Санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг Монгол, Англи хэлээр бэлтгэн ирүүлэх.

Дээр дурдсан хамрах хүрээний дагуу ажлын төлөвлөгөө гарган, Захиалагчид танилцуулан, зөвшилцөж баталгаажуулсны үндсэн дээр үйлчилгээг үзүүлнэ. Зөвлөх үйлчилгээний баг нь Захиалагч талтай тогтмол харилцаж, бүх талын мэдээллээр ханган ажиллана.

#### **Хугацаа:**

Хөндлөнгийн аудитын нь тайлан, дүгнэлт, санал, зөвлөмжийг 2025 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор эцэслэн ирүүлнэ.

#### **Үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлага:**

1. Олон улсад нэр хүнд бүхий аудитын хуулийн этгээд эсвэл түүний салбар, төлөөлөгч байх;
2. Гадаад партнер (зөвлөх)-тай байх;
3. Партнер нь ажлын 20-оос доошгүй хоног Монгол Улсын Хөгжлийн банкны байранд байрлан ажиллах боломжтой байх;
4. Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг 2022, 2023 онуудад тус тус үзүүлсэн байх;
5. Банк, санхүү, хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын санхүүгийн тайланд 3-аас доошгүй удаа аудитын үйлчилгээ үзүүлсэн туршлагатай байх;
6. Аудитын үйлчилгээ үзүүлэх багын 3-аас доошгүй гишүүн нь банк, санхүү, хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийж байсан 3-аас дээш жилийн туршлагатай байх;